

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 3 сарын 25 өдөр

Дугаар 07


Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА СОНГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.10 дахь заалтыг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналаар Чулуун овогтой Чинзоригийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар сонгосугай.

ГИШҮҮД:



Ц.БИЛЭГ-ӨРНӨХ

Б.ЗОЛЖАРГАЛ

Ч.ТЭМҮДЭР

Л.ОЧИРМАА

Ч.БАДМААРАГ

Б.ЭНХ-АМГАЛАН

Ч.ЛОДОЙРАВСАЛ

А.ДАВААЗОРИГ

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 3 сарын 25 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ДЭД ХОРООДЫГ ШИНЭЧЛЭН БАЙГУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дэх заалтыг үндэслэн компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгосонтой холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр тус тус шинэчлэн байгуулсугай.

- 1.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны бүрэлдэхүүн:

Дарга Б.Энх-Амгалан
Гишүүд Ц.Билэг-Өрнөх
Ч.Лодойравсал

- 1.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүн:

Дарга Ч.Тэмүдэр
Гишүүд А.Даваазориг
Б.Энх-Амгалан

- 1.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүн:

Дарга Ц.Билэг-Өрнөх
Гишүүд Ч.Лодойравсал
А.Даваазориг

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 3 сарын 25 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА ТОМИЛОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 82 дүгээр зүйлийн 82.1 дэх заалтыг үндэслэн компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын үүрэгт ажилд Батжаргал овогтой Бадамцэцэг/МБ83120301/-ийг улируулан томилсугай.
2. Холбогдох хууль, дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 3 сарын 25 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

КОМПАНИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.2 дэх хэсгийг үндэслэн **ТОГТООХ** нь

1. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн Бизнес төлөвлөгөөг Хавсралт №1-ээр баталсугай.
2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, Төлөөлөн удирдах зөвлөлийг холбогдох мэдээллээр хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Золжаргал)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 3 сарын 25 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХУВААРЬ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйл, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.13 дэх хэсгийг үндэслэн компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ** нь

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны ээлжит хурлын хуваарийг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай.
2. Энэхүү тогтоол 1 дэх хэсэгт заасны дагуу Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлыг тогтоосон хугацаанд хуралдуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Б.Бадамцэцэг)-д, хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дарга (Ч.Чинзориг)-т үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ХЭ-ийн ээлжит
2022 оны 3 дугаар сарын 25 -ны өдрийн
11 тоот тогтоолын Хавсралт №1

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХУВААРЬ

№	Хурал	Хуралдах огноо
1	Жилийн эцсийн ээлжит хурал	2 сарын 15-ны дотор
2	2 дугаар улирлын ээлжит хурал	4 сарын 15-ны дотор
3	3 дугаар улирлын ээлжит хурал	7 сарын 30-ны дотор
4	4 дугаар улирлын ээлжит хурал	10 сарын 15-ны дотор

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 3 сарын 25 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.4 дэх хэсэг, 53 дугаар зүйлийн 53.1.2 болон 53.5 дахь хэсэг, 54 дүгээр зүйлийн 54.1, 54.2 болон 54.3 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.7 дахь заалт болон Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.22-д заасныг үндэслэн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Компани хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргах болсонтой холбогдуулан компанийн тухай хуулийн 53.1.2-д заасны дагуу хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлсүгэй
2. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журмыг Хавсралт 1-ээр баталсугай.
3. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх шаардах хуудсыг Хавсралт 2-ээр баталсугай.
4. Компанийн эргүүлэн худалдан авах хувьцааны үнийг сүүлийн нэг сарын жигнэсэн дундаж үнэ болох 21/Хорин нэгэн/ төгрөгөөр тогтоосугай.
5. Компанийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын дагуу хувьцаа эзэмшигчид мэдэгдэхийг Гүйцэтгэх захирал (Б.Золжаргал)-д үүрэг болгосугай.
6. Энэхүү тогтоол болон журмын хэрэгжилтийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийг холбогдох мэдээллээр хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Золжаргал)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ